

И. Монголын эртний түүхийн асуудал

ВОЙДА БА БОЙЛА

(Эртний нэгэн мажар цол хэргэмийн тухай)

Обрушански Барбола
Унгарын монголч эрдэмтэн

Өгүүллийн товч утга: Войда ба бойла хэмээх эртний мажар цол хэргэмийн гарал, үүслийг олон хэлнээс харьцуулан судлаад, монгол мэтийн нүүдэлчдийн төр ёстой холбоотой байсныг жишээ баримтаар нотолсон байна.

Түлхүүр үг: Войда, бойла, боебод, тэргүүлэгч, Транссилвани, дьуло, бойлас

Войда нь мажарчуудын эртний нэгэн цол байжээ. X зууны дундуур Византийн эзэн хаан VII Константин мажар овгийн удирдагч нарыг "боебод" нэрээр дуудаж байв. Үүнд: Уг газрыг боебодоо, Лебедигийн дараагаар нэрлэж, тэр Лебеди нь хүний нэр болон цолыг бусад овгийн тэргүүлэгч нар шиг боебодоор дууддаг"¹ хэмээжээ. Византийн эзэн хааны тэмдэглэсэн "боебод" цол нь сурвалжийн мэдээгээр хааны дараагийн долоон овгууд анд бололцсон гэрээ тогтсоны өмнөх-мажар овог-аймгийн тэргүүлэгч нарын цол байсан байна. Византийн эзэн хааны үзлээр "Түрк буюу Мажар нарын ахлагч бол боебод юм, тэд нарыг анхны боебод захирч байв"².

Боебод цол цаашдаа мажар түүхэнд уламжлагджээ. Гэвч сурвалжид зөвхөн 1173 оноос хойш дурьдаж, Мажар улсын зүүн хэсэг Транссилваний цэргийн ба иргэний засаг захиргааны албан тушаалтнууд уг цолыг хэрэглэж байв.

Войда үгтэй холбогдох судалгаа

Войда үгийн угсаа гарвалыг мажар түүхч нар XIX зууны үеэс өдгөө хүртэл нарийн судлаагүй явж иржээ. XIX зууны үед анх удаа Германы хэл зүйч Ёсеф Буденц серб Миклошич Винобонгийн номын тухай танилцууллага бичиж, үүнтэй төстэй мажар болон славян үгийг цуглуулсан аж. Энэ жагсаалтад "войда бол шинэ славяны Войводатай төстэй юм"³ гэжээ. Тэр серб судлаач энэ хоёр үгний

¹ Moravcsik, 1988. 42

² Moravcsik, 1988. 42

³ Budenz, 1862. 313.

хоорондын холбооны тухай бичээгүй, гэвч цаашдаа мажарын судлаачид войда гэдэг үгийг славян ноёны цол гэж хүлээн авсан байна. XIX зууны мажар үгийн их тайлбар тольд войда гэдэг үг славян гаралтай гэдгийг хүлээн зөвшөөрсөн, үгийн үндсийг “бой”-той дүйцүүлэн, утгыг нь “дайн, байлдаан” гэж тэмдэглэжээ⁴.

XX зууны эхэнд Мелик Янош гэгч мажар хэл зүйч войда үгийн үндсийг “вой” гэж үзсэн ба водить - удирдах хэмээн тайлбарласан⁵. Янич Иштван хэмээх түүхч войда үгийг түүнтэй бараг адилхан славян үгээр тэмдэглэсэн байдаг. XX зууны үеийн 30-аад онд мажар түүхч Хумон Балинт таван боть Мажарын түүх гэдэг бүтээлдээ энэ талын судалгааны үр дүнг дүгнэжээ. Тэрээр “Овгийн тэргүүлэгч нь мажараар ходнодь-славян хэлээр войда, войвода-байсан, тэр нь олон угсаатнуудын дарга гэдэг байсан. Түүнийг угсаатнуудын хуралдайгаар өргөмжилдөг журамтай байсан” гэжээ.

1945 оноос хойш войда үгийн гарлыг дахин судлаагүй учраас тэдний тайлбар хэвээрээ үлджээ. Зарим хэл зүйч, жишээлбэл: Ердеди Ёсеф мажар үгийг румын “вода” буюу “тэргүүлэгч”-тэй нийлүүлж, мажарчууд уг цолыг румынээс авсан гэж үзсэн юм. Тэрхүү санааг Кришто Дьуло хэмээх түүхч эсэргүүцээд, дундат зууны үеийн турш Румынд ноёлдог войда, мажар хаанаас томилогдож байсан гэжээ.

Мажар эртний үгийн тайлбар толь бичгийн гурван боть 1970 онд хэвлэгдсэн болой. Үүнд: тэр үе хүртэл судлагдсан үгийн тайлбарыг оруулсан. Үүнд ч войдаг славян үгээр тэмдэглээд, угсаа гарвал нь эртний орос хэлэнд буй гэж үзжээ. Тэр тайлбар арай буруу байсан, яагаад гэвэл одоо ч хүртэл орос хэлний тайлбар толь болон бусад түүхийн сурвалж бичигт ийм тушаалтны нэр, цол хэргэм олдоогүй байна.

Мажарын судлаачид дотор арай өөр байр суурийг Немет Дьуло нэрт түркч эрдэмтэн баримталсан билээ. Тэрбээр “X зууны үед Трансильванид байгаа войда нар булгар-турк гаралтай, соёлтой” гэжээ. Мөнхүү мажар дьуло гэдэг цолтон эртний

⁴ Czuczor-Fogarasi, 1874. 743

⁵ Melich, 1921. 145

мажарын түүхэнд хан, IV зуунаас хойш Транссилванид ноёрхогч войда байсан гэж үзсэн байна.

Энэхүү судалгааны чиглэлийг цаашдаа Кришто Дьуло гэдэг түүхч үргэлжлүүлэн, бие даасан судалгааг хийж “Войда үг нь мажар хэлэнд славян гаралтай гэж эрдэмтэд үздэг. Миний бодлоор войда гэдэг нэр Транссилваний дарга буюу шүүгч гэдэг үг бололтой. Уг нутагт дээр үед нэг хэсэг нь славян байсан гэвч ихээхэн хэсэгт булгарууд байсан гэж үзэж болно. Ийм учраас войда гэдэг цолыг булгарууд ашиглаж байсан байх аа” гэжээ.

Дундат зууны үед Оросын ханлигуудад нэгэн онцлог цол-боярыг хэрэглэсэн, гэвч тэр нь олон судлаачдын үздэг жинхэнэ славян үг биш, харин булгар гаралтай ажээ. Бояр, войда ба войвода зэрэг цол хэргэмийн үндэс нь “вой/бой” болох юм. Оросын тайлбар тольд; “война, воини” үгэнд дараах тайлбар байгааг үзэж болно. Үгсийн үндэс бол бой” яг тэндээс войвода гэдэг үг гарсан. Үгийн үндсэн утга нь дарга” гэжээ.

Булгарын эртний үгийн тайлбар тольноос бид нар дээрх асуудлын талаар маш тодорхой хариулт авч болно. Үүнд войвода маш эртний-түрэгийн үеийн өмнөх булгар цол хэргэм болж, түүний үндэс нь “бой” байсан юм. Үгийн утга нь “удирдагч”. Тайлбар тольд: войвода үгийг ч олж үзэж болно. Водач гэдэг үгийн утга ч удирдагч бөгөөд мөн эртний цол хэргэм мөн. Войвода гэдэг үгийг славянчууд XIV-XVI зууны үед хэрэглэсэн юм. Дээр тэмдэглэсэн олон янзын судлаачдын санаа оноог харьцуулбал войвода гэдэг үг нь дан славян үг биш, харин түүний гарал нь маш эрт үеэс янз бүрийн угсаатнуудад хэрэглэж байсан цол байсан бололтой. Тэгвэл гарлыг славянчуудын түүхэн дотор биш, нүүдэлчин соёл иргэншлийн дотор хайх ёстой. Зүүн Европт Хүннү улс мөхөсний дараа үлдээсэн хүннү угсаатнууд-булгар болон авари нар-цаашдаа мажарууд тусдаа улсаа байгуулсан. Дунай мөрний Булгар улсын анхны хэдэн тэргүүлэгч “хан” хэмээн бичигдсэн бөгөөд түүний дэргэд зургаан бойла түшин сууж байв. Тэд нарын улсын тогтолцоо нь Евразийн нүүдэлчдийн зохион байгуулалтыг авч хэрэглэсэн юм⁶.

⁶ Цегледи Каталин хэл зүйч тайлбарлал өгсөн юм.

Сурвалжид байгаа бойла. Евразийн нүүдэлчин соёл иргэншилд нэгэн цол хэргэм-бойла-нэр ба утгаар нь войдатай адилтгаж болохоор байна. Бичгийн дурсгалд Төв Азийн түрэгийн Тоньюкукт зориулсан гэрэлт хөшөөг хэлж болно. Үүнд: “Би Эльтерес хаан Тоньюкук бойла бага таркантай хамт байв”⁷.

Монгол улсын Хөвсгөлийн Ринчинлхүмбэ суманд байгаа Орюк хаданд хоёр мөртэй түрк рүни бичгийг археологич нар олсон. Үүний 2 дугаар мөрөнд “түрк бойла тарканы алдар” гэсэн үг бий⁸. Үүнээс гадна Булган аймгийн Сайхан сумаас олдсон уйгар бичгийн 2 дугаар мөрөнд ч “бойла кутлуг” гэдэг хэргэм цол дурьдагдсан буй⁹. Зүүн Европын Карпатын сав газарт олдсон рүни бичгээс Мажар улсын Надьсентмиклошийн үнэт дурсгалын нэгэн алтан аяганд “бойла” гэдэг хэргэм тэмдэглэгдсэн болно. Рона-Таш Андраш мажар судлаач бойла нь эртний түрк болон Дунай мөрний булгаруудад бойла-булэ-пулэ хэвээр үлдсэн юм¹⁰. Клаусон хэл зүйч бойла гэдэг үг нь прото буюу эртний булгар үүсэлтэй, гэвч нилээд эртний Хүннүгийн үед анх удаа дэлгэрсэн бололтой¹¹. Бойла өөрөө хааны дараагийн хамгийн өндөр цол, зүүн хэсгийн удирдагч байсан бололтой¹². Енисейн уйгар бололтой нэгэн булшны дурсгалд ичакри бойла гэгдэж байна. Үүнийг Томсэн ордоны нэгэн түшмэл гэж үзсэн¹³. Рона-Таш Андрашийн үзлээр бойла нь Дунай мөрний булгаруудын хооронд уламжлагдан хэрэглэж, тэдний хооронд Бойлас гэдэг овог нэр дундат зууны үед арай хожуу дэлгэрчээ. Бойлас угсаатан Византын сурвалж бичгүүдэд бас тэмдэглэгдсэн¹⁴. Тэдний нөлөө одоогийн Булгар нутгаас Трансильвани хүртэл дэлгэрээд, уг нутгийг Мажарын Иштван хаан эрхшээлдээ авчээ.

Дээр тэмдэглэсэн Булгар улсад буй эртний дөрвөн прото-булгар дурсгалд бойла гэдэг цол тэмдэглэгдсэн болно. Хамгийн эртнийх нь Омуртаг ханы (814-831) үе бөгөөд тэр бойла нь Тукош мөн. Шимеон ба Петер хааны (927-969) үед бойла нь Моштиц байсан. Хамбарлын дурсгалуудаас үзэхэд “ециргу бойла” цол нь хааны

⁷ Győrffy, György, 1977. 70.

⁸ Болд, 1990. 80

⁹ Болд, 1990. 89

¹⁰ Rona-Tas, 1985. 245

¹¹ Clauson, 1972. 385

¹² Clauson, 1972. 385

¹³ Rona-Tas, 1985. 248

¹⁴ Rona-Tas, 1985. 250

дараагийн хоёр дахь цол байсан байна. Булгаруудын хамгийн дээд зиндааны цэргийн цол нь зуун буюу баруун жигүүрийн удирдагч бөгөөд үүнийг хааны ах дүү нараас томилдог байв. Булгарын Филипи хошоонд бойла нь хааны харъяат байжээ. Мөн үүнийг Преславын дурсгалаас харж болно. Булгарч эрдэмтэн, Бесевлиевичийн үзлээр бойла зөвхөн цэргийн хэргэмээс гадна гадаад харилцааны үүрэгтэй байсан бололтой¹⁵. Дээр өгүүлснээс үзэхэд бойла цол хэргэм Төв Ази ба Зүүн Европын Хүннү гаралтай угсаатнуудын дотроос олдож байна. Нэгэн тусгай газар-одоогийн Румынд байгаа Транссилванид¹⁶ хүннү ба булгарууд амьдарч байсан. Мажар улсын секел ба угсаатан Аттила хүннү хааны хүү, Чобагаас¹⁷ шууд үг эхтэй гэдэг. Мажарын войда цол хэргэм яг Транссилванид дэлгэрсэн юм. XI зууны эхэнд Дьула гэдэг уг газрын эзэн Иштван мажар хаанд ялагдсаны дараа войда бол уг газрын том түшмэл болсон байна. Бичгийн дурсгалууд дутмаг учир бид нар войда цол дьулатай адил гэж хэлэх аргагүй.

Евразийн нүүдэлчид хэрэглэж байсан “бойла/бойда” гэдэг хэргэмийг нэр ба үүргээр нь мажар “войда” үгийн үндэстэй харьцуулж болно. Войдаг хэл зүйн шинжилгээгээр бойлагтай нэг үндэстэй гэж болно, яагаад гэвэл эл хоёр цол “бой” үндсэн, үгийн эхэнд байгаа “б” ба “в” авиа эртний “w” авиагаас гарч байсан бөгөөд үгийн дундад байгаа “ла” ба “да” дагавар нь бас арай эртний дагавар юм. Бойла /байда/ войдаг ингэж холбож үзэж болох юм. Үгийн үндэс “woy” байж, w-гээс “б” ба “в” болон хөгжсөн. Немет Дьуло гэгч түркч эрдэмтэний бодлоор мажар болон алтай хэлэнд ч үгийн эхэнд байгаа “б” ба “в” авиа олон удаа солигддог байна. Цегледи Каталин мажарын хэл зүйчийн бодлоор дээр тэмдэглэгдсэн “бой” үндэс нь мажар хэлэнд “фей” (толгой) үгэнд ч байгаа, ийм нөхцөл байдлаар войда ба бойла нь удирдагч ба толгойлогч гэсэн утгатай. Эртний мажар хэлний тайлбар тольд войда үгийг нь мажар хэлэнд заримдаа ийм утгаар хэрэглэж байсан бүлгээ.

Хэл зүйн шалтгаанаас гадна бойла ба войдаг үүргээр нь ч харьцуулж болно. Петер Добрев гэгч булгар эрдэмтэн эртний булгар нийгмийн байгуулалд улсын удирдагч 6 хүн болоод бас нэгэн хаан, нийлээд долуулаа байсан. Уг байгуулалт яг

¹⁵ Besevliev, 1955. 124

¹⁶ Транссилвани нь эрт дээр үед хүннүгийн газар байсан. Тэд нарын нэгэн үлдэгдэл нь мажараар ярьдаг секел угсаатнууд мон. Уунийг “Ердель” гэдэг. Уг газар 1920 он хуртэл Мажар улсын нэг хэсэг байсан.

¹⁷ Чоба үнэхээр хүний нэр биш, тэр нь хүннүгийн нэгэн цол хэргэм байсан бололтой. Аттила хааны отгон хүүг Ирнэкээр нэрлэсэн. Чоба нь эртний чубан цол байсан бололтой.

эртний мажарт байсан бөгөөд 6 боебод ба нэгэн удирдагч (прото) нийт 7 хүн байжээ. Цаашдын мажарын түүхийн зарим хэсэг тодорхой биш, бид нар боебод цол мажар овог нар цусан холбоо (анд бололцох ёс) тогтоосны дараа тэр цол хэргэм хэвээрээ үлдсэн үү? үгүй юу? гэсэн асуудал чухал, анхаарал татах зүйл.

Войда гэдэг цол Мажар ханлигын зүүн хэсгийн бүрэн эрхтэй захирагч, шүүгч байжээ. Булгарын бойлаг ч улсын зүүн хэсгийн удирдагч байсан гэж үзэж болох байна. Захиргааны зүүн хэсэг нь эртний Хүннү гүрэнд маш хүндэтгэлтэй хэсэг болж, шаньюйг залгамжлагч хан хөвгүүн яг тэр хэсгийг захирч байсан аж.

Транссилваний үндэс

Эртний мажар сурвалж бичгүүдэд войда цолыг бараг тэмдэглээгүй, гэвч төвлөрсөн Мажар улсын засаг захиргааны тухайд хэсэг бусаг мэдээ бий. Ийм нөхцөл тул Мажар улсын төвөөс хол байгаа нутгийн захиргааны тухай бага сага мэдээ авч болно. Мажар улсад XI зууны эхээр латин хэлний бичгийн соёл зөвхөн хааны ордон ба хааны захиргааны төвд түүнчлэн улсын зохих хэсэгт засаг захиргааны уламжлалт аман ёсыг авч хэрэглэдэг байжээ. Мажар эрдэмтэн Дьорфи Дьордийн үзлээр Христос шашин хүчээр хүлээн авсан Мажар улсад аймгийг “дүкс” буюу тайж захирч, зөвхөн Транссилванид нилээд эртний войда цол үлдсэн. Тэр нь 1111 оноос “принепс” хэмээн тэмдэглээд 1200 оноос бичгийн сурвалжид “войда” гэж дурдагдсан байна. XIV зууны дундуур бичигдсэн “Кепеш Кроника” гэдэг мажарын сурвалжид Транссилванийн Дьула ялагдсаны дараа мажарын Иштван хаан өөрийн нэгэн хамаатан, Ердоелви Зултаныг уг нутгийн эзнээр томилсон байна¹⁸. Дьорфи Дьорд түүнийг анхны войда гэж үзсэн боловч, үүнтэй холбогдох бичгийн мэдээ сэлт байхгүй. Нөгөө сурвалжид өөр нэгэн том нутгийн эзний тухайд мэдээлсэн буй. Мажар ханлигийн зүүн хэсэгт Вата гэдэг томоохон удирдагч 1046 оноос христос шашны эсрэг нэгэн том хөдөлгөөнийг үүсгэжээ. Тэр нэрийн угсаа гарвалыг хэн ч нарийн судлаагүй бас войдатай ямар холбоотой байсныг сонирхоогүй байна. Сурвалжийн мэдээгээр бол Мажарын зүүн хэсэгт маш нөлөөтэй

¹⁸ Képes Kronika. 66

удирдагч байсан гэж үзэж болохоор байна. Түүний эзэмшсэн газар дээр үед Бойла жупоны¹⁹ газраас маш ойрхон байсан аж.

Анунимусийн “Мажарын түүх” гэдэг бүтээлд Мажарчуудтай анд бололцсон хүннү овгийн нэгэн удирдагч нэр нь “Вуйта”, нөгөө нь “Буйта” байсан. Бидний олсон мэдээгээр хүний нэр ба цол олонтаа солигддог учраас тэдний нэр войда үгтэй холбоотой юм биш үү гэдэг бодол төрж байна. Цаашдаа үүнийг нарын судлаж шийдвэрлэх хэрэгтэй.

Дьорфи Дьорд мажарын Бела хааны нэрийг бойлагаас гаралтай гэж үзсэн байна. Үүний үндэс нь IX зууны булгар хааны гэр бүлийнхэн “бүлэ” гэдэг хүний нэр байсан бололтой. Дээрх мажар эрдэмтний үзлээр нэр нь булгар дурсгалд биля, эсвэл булгар-турк ичиргу бойлатай адил учраас Бела гэдэг мажар нэр нь турк бойла цолын нэгэн янз мөн гэжээ. Тэрчлэн бойла гэдэг нэр хүний нэрээр мажар ард түмэнд уламжлагдан залгамжлагдсан болно²⁰. Уг эрдэмтэн дээр дурдсан Надьсентмиклошийн үнэт зүйлийн талаар Хойт-Транссилваний нэгэн овгийн удирдагч, Айтонгийн эдлэлүүдээ байсан, уг дурсгалд байсан Бойла гэдэг эзний залгамжлагч мөн гэсэн байна²¹.

Дээрх бичгийн мэдээгээр Транссилванид байсан войда цол нь эртний түүхтэй дээр тэр үеийн нүүдэлчин иргэншилтэй нягт холбоотой. Мажарын войда латин бичгийн сурвалжтд анх удаа 1177 ба 1183 онд тэмдэглэгдсэн. Транссилваний ихээхэн газар нь 1263 оноос хойш войдагийн захиргаанд орж, XVII зууны эцэст Мажар улсын нэгэн том иргэний ба цэргийн удирдагч байжээ.

Abstract: The article provides a hypothesis on possible links between the two Magyar titles - vojda and bojla, and the customs of the Mongol nomadic statehood.

Ном зүй

BELLUS, Ibolya, (ford)
1986. Kйpes Krynika.

¹⁹ Бойла жупоны угсаа гарал одоо ч хүртэл тодорхой биш. Зарим эрдэмтэн булгар, зарим нь авар, цөөнх хэсэг нь мажар байсныг дэмжиж байна.

²⁰ Дьорфи Дьорд, 1977. 98

²¹ Дьорфи Дьорд, 1977. 165

Besevliev, V.

1955. What was the title etzrigou boilas in the protobulgarian inscriptions? In: Byzantinoslavica. XVI. Prague. 120-124

BOLD, L.

1990. БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс. УБ.,

BUDENZ, Jyzsef

1862. Kъnyvismertetёs Lexicon Palaeoslavenico Latinum, emendatum auctum. In: Nyelvtudomбnyi Kъzlemйnyek, 1. 306-316

CLAUSON, George

1972. An Etimological dictionary of Pre-thirteenth century Turkish. Oxford.

DOBREV, Peter

1995. Ezikyt na Asparukhovite i Kuberovi bylgari, Rechnik i Grammatik. Sofia

DUVANDIH, Catherine

1998. A romбн нйр тцртйnete. Maecenas. Budapest.

ERDŐDI, Jyzsef

Egyszerejtёs, vagy cirцvidёlёs. In: Magyar Nyelv, 71. 60-61.

FEHЙR, Gйza

1940. A bolgбr-тцрцкцкк szerepe йs mўveltsйge. Budapest, Kirбlyi Magyar Egyetemi Nyomda.

FONT, Mбrta

1998. Oroszorszбg, Ukrajna, Rusz. Budapest.

GABAIN, von A.

Alttўrkische grammatik. 3. auflage. Otto Harrassowitz. Wiesbaden

GOLDEN, Peter B.

1980. Khazar Studies. Budapest

GYŐRFFY, Gyцrgy

1972. Az Ёрпбд-kori szolgбlynevek кйрдйсйhez. In: Тцртйneti Szemle, 312-320.

GYŐRFFY, Gyцrgy

1977. Istбн kirбly йs mўve. Bp.

GYŐRFFY, Gyцrgy (szerk.)

1986. A magyarok elцdeirцл йs a honfoglalбsryl. Bp.

HELLER, Mihail

2000. Az Orosz birodalom története. I. Osiris Kiadó, Budapest.

JANITS, Iván

1912. Az erdélyi vajdák igazságszolgáltatás oklevélady működése 1526-ig.

KAZHDAN, Alexander, P.(Ed.)

1991. The Oxford Dictionary of Byzantium. Oxford.

KŰPES Krynika

1988. Budapest, Európai Könyvtár. (Ford: Bellus Ibolya)

KRISTÓ, Gyula

1988. Erdély a XI-XIII. századi történetéhez. In: Tanulmányok Erdély történetéből.

Szerk. Rócz István. 60-65. Debrecen.

KRISTÓ, Gyula

1999. A tizenegyedik század története. Budapest.

KRISTÓ, Gyula (szerk.)

1994. Korai történeti lexikon. IX-XIV. század. Budapest

LESSING, Ferdinand

1960. Mongolian-English Dictionary. Bloomington.

MACKERRAS, Colin (szerk.)

1972. The Uighur Empire according to the Tang Histories. A Study in Sino-Uighur relations. 744-840. Australian National University Press. Canberra.

MAKKAY, János - MÓCSY, András (szerk.)

MELICH, János

1921. Néhány szöveg magyarosítása. In: Magyar Nyelv, 17.

MELICH, János

1933. Adalékok az egyszejtéshez. In: Magyar Nyelv, 29. 269-274.

1988. Erdély története I. kötet.

MIKOS, József

A fehérvári keresztések 1193. évi oklevele. In: Magyar Nyelv, 31. 288-309.

MORAVCSIK, Gyula

1988. Az Árpád-kori magyar történet bizánci forrásai. Akadémiai Kiadó, Budapest.

NÉMETH, Gyula

1991. A honfoglaly magyarsбg kialakulбsa. Budapest.

RYNA-Tas, Andrбs

1985. A szarvasi тътarty felirata. In: Nyelvtudomбnyi Kцzlemйnyek 87:1, 225-248.

BENKŐ, Lyrбnd

1976. TESZ. Тцртйneti Etimolygiai Szytбr. III. Budapest, Akadйmiai Kiady.

VARGA, Jбnos (szerk.)

1997. Erdйlyi okмбnyтбr I. 1023-1300. Forrбskiadvбnyok. Akadйmiai Kiady, Budapest.

VERNADSKY, G

1955. Ancient Russia, A History of Russia. The Murray Printing Co. Forge Village.